



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

XXVII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын 27-р хуралдаан 2020 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд 90 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдлын талаар;

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
Т.Мөнхсайхан

2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэж болзошгүй үйл явдлын 10 дахь эрсдэлийн үнэлгээ;

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
Т.Мөнхсайхан

3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах эсэх талаар;

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга,
бригадын генерал Г.Ариунбуян

4. Бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс үе шаттай эхлүүлэх талаар;

Боловсрол, шинжлэх ухааны сайд
Л.Цэдэвсүрэн

5. Эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг 8 дугаар сард татан авах захиалгат нислэгийн талаар;

*Гадаад харилцааны яамны
Консулын газрын захирал
Л.Мөнхтүшиг*

6. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг нэмэгдүүлэх тухай;

*Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ёндон*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

*Нэг. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт:*

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 01 дүгээр хэсэгт заасан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг 2020 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд сунгах, энэ хугацаанд хилийн боомтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

Хоёр. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэнд:

2.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн нөхцөлд боловсролын бүх шатны сургалтын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг үе шаттай эхлүүлэх талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

*Гурав. Гадаад харилцааны сайд Н.Энхтайван,
Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,
Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:*

3.1. Гадаад улс орнуудаас эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг 8 дугаар сард татан авах төлөвлөгөөний дагуу холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;

Дөрөв. Гадаад харилцааны сайд Н.Энхтайван,
Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,
Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,
Гадаадын иргэн, харьяатын газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Мөрөн нарт:

4.1. Гадаад улс орноос Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүд, Монгол Улсад байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэд, Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэд, тэдний дундаас төрсөн хүүхдийг хилийн агаарын болон автозамын боомтоор нэвтрүүлэх талаар холбогдох судалгааг хийж танилцуулах;

Тав. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад:

5.1. Уул уурхай, дэд бүтэц болон бусад салбаруудад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, аж ахуйн нэгж байгууллагад ажиллах гадаадын ажиллах хүчний асуудлыг холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

Зургаа. Гадаад харилцааны сайд Н.Энхтайван,
Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ёндон,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:


6.1. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн судалгаа хийх;

6.2. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг сайжруулах, хилийн боомтуудын нэвтрэх гарцын тоог нэмэгдүүлэх, боомтын цагийн хуваарийг уртасгах зэрэг асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

Долоо. Улсын онцгой комиссын гишүүдэд:

7.1. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг салбар бүр боловсруулах;

ДАРГА,
ШАДАР САЙД



Я.СОДБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

A large, stylized handwritten signature in black ink, belonging to D. Sanzhaa.

Д.САНЖАА